



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 1/202

Улаанбаатар хот

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан журмын 4 дүгээр зүйлийн 4.2, 4.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.3, 5.10, 5.13 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зэвсэгт хүчний 119 дүгээр анги үүсэн байгуулагдсаны 51 жилийн ойн баяр, Нийслэлийн өдрийг тохиолдуулан дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргаж, идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа хавсралтад дурдсан нэр бүхий иргэдийг дүүргийн “Хүндэт тэмдэг”, Засаг даргын нэрэмжит “Өргөмжлөл”-өөр шагнасугай.

2. Дүүргийн “Хүндэт тэмдэг”, Засаг даргын “Өргөмжлөл”-д дагалдах мөнгөн шагналыг холбогдох шагналд тодорхойлсон байгууллагын зардлаас гаргахыг зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар /Б.Амартүвшин/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ